



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 700

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар хийгдсэн, 23 нэрийн нийт 49,436,333,365.00 (дөчин есөн тэрбум дөрвөн зуун гучин зургаан сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун жаран тав) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Г.Ёндон болон хавсралтад заасан байгууллагын захирал, дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Байгууламжийн доорх газар эзэмших эрхийг хүлээн авсан байгууллагын нэр дээр баталгаажуулах, шилжүүлэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 23 дугаар тогтоолын хавсралтын 4 дүгээр мөрийг хүчингүй болсонд тооцугай.


4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 1-р дугаар сарын 14-ны өдрийн
700 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН,
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Хүлээн авч бүртгэх аймаг, төрийн өмчит байгууллага
1	Гадна дулааны 1-р хэлхээ /м/ ф530- 325мм L=2500м	2023-07-20	16,236,467,937.00	16/2023А, 16/2023Б	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК
2	Дулааны насосын станц	2023-07-20	720,719,473.00	16/2023А, 16/2023Б	
3	Дулааны насос	2023-07-20	924,532,735.00	16/2023А, 16/2023Б	
4	Сувагчлал	2023-07-20	865,631,108.00	16/2023А, 16/2023Б	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК
5	Дулаан дамжуулах төв УДДТ-1, Уурхайчин - 2, 3 хороолол	2023-07-20	936,339,118.00	16/2023А, 16/2023Б	Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
6	Дулаан дамжуулах төв УДДТ-2, Уурхайчин - 2, 3 хороолол	2023-07-20	1,537,102,818.00	16/2023А, 16/2023Б	
7	Дулаан дамжуулах төв УДДТ-3, Уурхайчин - 2, 3 хороолол	2023-07-20	2,134,458,843.00	16/2023А, 16/2023Б	
8	Дулааны шугам 2-р хэлхээ, Уурхайчин -2, 3 хороолол	2023-07-20	2,972,030,633.00	16/2023А, 16/2023Б	
9	Цэвэр усны шугам, Уурхайчин - 2, 3 хороолол	2023-07-20	3,454,215,742.00	16/2023А, 16/2023Б	
10	Цэвэр усны шугам, Уурхайчин - 2, 3 хороолол	2023-07-20	1,355,290,244.00	16/2023А, 16/2023Б	
11	Ариутгах татуургын шугам, Уурхайчин - 2, 3 хороолол	2023-07-20	2,460,841,744.00	16/2023А, 16/2023Б	

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Хүлээн авч бүртгэх аймаг, төрийн өмчит байгууллага
12	6кВа цахилгаан дамжуулах шугам, Уурхайчин - 2, 3 хороолол	2023-07-20	1,023,054,024.00	16/2023А, 16/2023Б	Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
13	10кВа-ын цахилгаан хуваарилах төв,	2023-07-20	1,574,423,001.00	16/2023А, 16/2023Б	
14	Цахилгаан дамжуулах дэд станц /ХТП/	2023-07-20	421,473,676.00	16/2023А, 16/2023Б	
15	Цахилгаан дамжуулах дэд станц /ХТП/	2023-07-20	421,473,676.00	16/2023А, 16/2023Б	
16	0.4 кВа-ын цахилгаан дамжуулах кабель шугам Уурхайчин - 2, 3 хор.л	2023-07-20	228,806,798.00	16/2023А, 16/2023Б	
17	Цэвэр усны насосын станц, Уурхайчин - 2, 3 хороолол	2023-07-20	1,398,487,833.00	16/2023А, 16/2023Б	
18	Усан сангийн насосын станц /резервуар/	2023-07-20	612,793,265.00	16/2023А, 16/2023Б	
19	Авто замын гэрэлтүүлэг	2023-07-20	1,239,282,820.00	16/2023А, 16/2023Б	
20	Явган зам, ногоон байгууламж	2023-07-20	690,699,764.00	16/2023А, 16/2023Б	
21	Уурхайчин хорооллын авто зам	2023-07-20	7,657,217,702.00	16/2023А, 16/2023Б	
22	Ногоон байгууламж	2023-07-20	260,578,774.00	16/2023А, 16/2023Б	
23	Хуваарилах шүүгээ	2023-07-20	310,411,637.00	16/2023А, 16/2023Б	
	НИЙТ ДҮН		49,436,333,365.00 (дөчин есөн тэрбум дөрвөн зуун гучин зургаан сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун жаран тав)	